

ХҮНД ҮЙЛВЭРЛЭЛ


Танилцуулага

2015

Монгол Улс байгалийн асар их баялагтай бөгөөд гадны улсууд “Minegolia” гэж нэрлэх нь ч бий. Байгалийн баялагаа эдийн засгийн эргэлтэнд эрчимтэй оруулж байгаа энэ үед уул уурхайн олборлолт нэмэгдэхийн хэрээр түүнийг боловсруулах, нэмүү өртөг шингээх нь чухал болоод байна.

Олборлон экспортлох эдийн засгаас аж үйлдвэржсэн эдийн засагтай болох нь Монгол Улсын зорилго юм. Хүнд үйлдвэрийг цогцолбор байдлаар хөгжүүлэн, эхний ээлжинд нүүрс химийн, зэс, төмөр, цайр зэрэг өнгөт болон хар төмөрлөгийн хүдрийг олборлон анхан, дунд, гүн боловсруулалт хийх зориулалттай, дараагийн удаад нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвартай, байгаль орчинд хор нөлөө багатай орчин үеийн дэвшилтэт технологи бүхий үйлдвэрүүдийг барьж байгуулахаар төлөвлөж байна.

Монгол улсын хувьд энэ салбарт Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Оюутолгой зэсийн баяжуулах үйлдвэр зэрэг томоохон газрууд өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж байна.



Country : Mongolia
Created from: World Development Indicators
Created on: 03/02/2015

Монгол улсын давуу талууд

- ◆ Монгол оронд 80 төрлийн ашигт малтмалын 1000 гаруй орд байдаг. Монгол Улсын ашигт малтмалын тогтоогдсон нөөц:
 - 20.6 тэрбум тонн нүүрс
 - 84.1 сая тонн зэс
 - 1.08 тэрбум тонн төмөр
 - 2.4 мянган тонн алт
 - 18.1 сая тонн хар тугалга
 - 332,6 сая тонн газрын тос
- ◆ Ашигт малтмалын асар их нөөцтэй, боловсруулах аж үйлдвэр хөгжөөгүй, үйлвэржих үйл явц дөнгөж эхлэж байгаагийн дээр нэмүү өртөг бүтээх боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын дэмжлэг их байгаа нь хөрөнгө оруулагчдад томоохон боломж, орон зай юм.
- ◆ Дэлхийн хоёр том зах зээлийн дунд оршдог болон зүүн хойд азийн бусад томоохон зах зээлүүдэд ойрхон газар зүйн байрлалтай.
- ◆ Дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжсэнээр дэд бүтэц улам сайжирч байна. Түүнчлэн, Монгол Улс транзит тээврийг хөгжүүлэх чиглэлээр хоёр хөрштэйгөө тохиролцоонд хүрч холбогдох гэрээ хэлэлцээр байгуулсан.
- ◆ Нээлттэй эдийн засаг, худалдааны нээлттэй бодлоготой бөгөөд бүс нутагтаа бага татвартайд тооцогддог. 2015 онд Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан. Цаашид бусад улсуудтай мөн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах бодлого баримталж байна.

Хүнд үйлвэрийн онцлох чиглэлүүд

- Газрын тосны үйлдвэр
- Зэс хайлуулах үйлдвэр
- Төмөрлөгийн үйлдвэр
- Нүүрс-химийн үйлдвэр
- Кокс-химийн үйлдвэр
- Автомашин угсрах болон машины эд анги үйлдвэрлэх үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт амжилттай ажиллаж буй хөрөнгө оруулагчийн төлөөлөл

“Байгалийн баялаг ихтэй ч Монгол Улс бүрэн судлагдаж, нээгдээгүй байгаа бөгөөд уул уурхай, металлургийн салбарын хөгжлийн боломж үнэхээр их байна.”

Оутотек Монголиа компаний гүйцэтгэх захирал Т.Гансүлд



Оутотек компаний түүх нь 1910 онд Зүүн Финляндад зэсийн хүдрийн томоохон орд илэрсэнээр уул уурхай, металлургийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Оутокумпу компанийг байгуулсанаас эхтэй. 2010 онд олон улсын зах зээлд гарахдаа компаний нэрийг Оутотек болгон өөрчилсөн бөгөөд өнөөдөр Оутотек компани нь эрдэс баялагийн боловсруулалт, металлургийн салбар дахь инженер, технологийн дэлхийн тэргүүлэгч компани юм.

Оутотек Финлянд компаний 100 хувийн охин компани болон Оутотек Монголиа компани 2013 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын толгойлогч компаниуд болох Оюу толгой, Эрдэнэт, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, МАК зэрэг компаниудтай хамтран ажилладаг тухайгаа Т.Гансүлд захирал ярих.

Уламжлалт SX-EW технологид хувьсгал гаргасан Оутотекийн VSF (Vertical Smooth Flow) технологид суурилсан катодын цэвэр зэсийн үйлдвэрүүд өнөөдөр Финлянд, АНУ, Болгар, Чили, Лаос, Орос, Мексик, Перу зэрэг улсад ажилладаг. Оутотекийн санал болгож буй VSF технологи нь исэлдсэн болон бага агууллагтай хүдрээс цэвэр зэсийг үр ашигтай ба байгаль орчинд хохиролгүй

гарган авах шийдэл гэдгээрээ онцлог юм. 2014 онд Давосын Дэлхийн эдийн засгийн чуулганаар жил бүр зарладаг байгальд ээлтэй шилдэг дэлхийн 100 байгууллага буюу Global 100 Index-ийг зарлахад Оутотек эхний гуравдугаар байрт орж уг жагсаалтыг манлайлж байна. Өөрөөр хэлбэл тэдний барьж байгуулах эрдсийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүд хүлэмжийн хий, элдэв хорт хий зэрэг ус агаарын хорт хаягдал дэгдэхээс бүрэн хамгаалсан, хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан технологийн цогц шийдэл юм.

“Бараа, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ, түүний эрэлт, нийлүүлэлт болон тодорхой төсөл дэх хөрөнгө оруулалтын сонирхол зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлсийн шууд нөлөөнд оршдог нь манай салбарын бизнесийн онцлог юм. Монгол Улсын хувьд Байгалийн баялаг ихтэй ч бүрэн судлагдаж, нээгдээгүй байгаа бөгөөд уул уурхай, металлургийн салбарын хөгжлийн боломж үнэхээр их байна. Түүнчлэн зах зээлд ойрхон байрлал болон боловсролтой боловсон хүчин нь Монгол Улсын давуу тал болдог.” гэж Т.Гансүлд захирал онцлов.

Оутотек

- Оутотек компани нь уул уурхай, олборлолтын салбарын технологийн туршилт, үйлдвэрлэлийн шийдэл, тоног төхөөрөмж болон үйлчилгээ нийлүүлэгч дэлхийн томоохон компаниудын нэг юм.
- Хүдэрээс эцсийн бүтээгдэхүүн хүртэл үйлдвэрлэлийн дэлхийн шилдэг технологийг эзэмшигч бөгөөд Оутотекийн VSF технологид суурилсан катодын цэвэр зэсийн үйлдвэрүүд өнөөдөр Финлянд, АНУ, Болгар, Чили, Лаос, Орос, Мексик, Перу зэрэг улсад ажилладаг.
- Байгальд ээлтэй шилдэг дэлхийн 100 байгууллага буюу Global 100 Index-ийг зарлахад Оутотек эхний гуравдугаар байрт орсон.

www.outotec.com

Засгийн газрын бодлого, дэмжлэгүүд

- ◆ Төрөөс аж үйлдвэрийн салбарыг хөгжлийн гол хөдөлгүүр хэмээн тодорхойлж Аж үйлдвэрийн яамыг байгуулсан.
- ◆ Төрөөс аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлогыг батлуулахаар УИХ хэлэлцэж байна. Энэ бодлогын гол зарчмууд:
 - Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл
 - Экспортын чиг баримжаатай, импортыг орлох, олон улсад өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих
 - Дэвшилтэт техник, өндөр технологи, инновацид суурилсан эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх
 - Төр, шинжлэх ухаан, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах
 - Тэгш байдал, шударга өрсөлдөөнийг хангах
- ◆ Хүнд үйлдвэрийг цогцолбор байдлаар хөгжүүлэхээр төлөвлөж хууль, эрх зүйн орчинг бүрдүүлсэн бөгөөд дэд бүтцийн асуудлууд шийдэгдэж байна.
 - Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор ҮТП
 - Эрдэнэтийн зэсийн баяжмал хайлах үйлдвэр ҮТП
 - Багануурын нүүрс-химийн үйлдвэрлэл ҮТП
- ◆ Хүнд үйлдвэр байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх боломжтой.
- ◆ Монголд үйлдвэрлэж байгаа хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг импортын татварын болон квотын аргаар дэмжих бодлого баримталж байна.

Холбоо барих

Ханойн Онон
Сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний хэлтсийн
ахлах мэргэжилтэн
Хөрөнгө оруулалтын газар
15141 ЗГ-ын XI байр, Самбуугийн гудамж-11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс
Утас: 976-11320706
Факс: 976-324076
Цахим хаяг: onon@investmongolia.com
Цахим хаяг: mergen@investmongolia.com

Ашигтай холбоосууд

Аж үйлдвэрийн яам
www.mi.gov.mn
Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор ХК
www.ssic.mn
Монголын үйлдвэржилт хөгжлийн төв ТББ
www.uildverjilt.mn